




ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Хөрөнгө оруулагчдын амралтын хугацаа дууссанаас үүдэн арилжааны идэвх нэмэгдэж эхэлжээ. Даваа гараг бүх нийтийн амралтын байсан тул биржүүд тухайн өдөр үйл ажиллагаагаа явуулаагүй болно.

S&P индексийн сагсанд багтах эрчим хүчний салбарын компаниудын хувьцаа АНУ-ын газрын тосны нөөц буурсантай холбоотойгоор өсөлттэй хаагдлаа. Хагас дамжуулагч үйлдвэрлэгч компаниудын хувьцаа өсөж, технологийн салбар мөн өсөлттэй байв. Харин урт хугацааны Засгийн газрын бондын өгөөж өссөнөөс үүдэн ус, дулаан, цахилгааны салбарын компаниудын хувьцааны ханш буурчээ.

БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Шадар сайд ноён Лю Хэ, АНУ-ын худалдааны төлөөлөгч ноён Роберт Лайтхайзер, Сангийн сайд ноён Стивен Мнучин нар Пүрэв гарагийн өглөө утсаар ярьжээ.

Талууд хоёр талын худалдааны хэлэлцээний таатай нөхцөлийг бий болгох чиглэлд дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр тохиролцсон байна. БНХАУ болон АНУ-ын эдийн засаг, худалдааны дээд төвшний хэлэлцээрийн 13 дахь үе шат ирэх 10-р сарын эхээр Вашингтон хотод болох юм.

Европ: АНУ болон БНХАУ-ын худалдааны маргаан хурцадмал байдлаас гаран, Хонг Конгын үймээн самуун намжиж, Англи улс Европын холбооноос гарах нь тодорхой болж буйгаас үүдэн Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа.

Англи улсад бүх нийтийн ээлжит бус сонгууль явуулах талаар Ерөнхий сайд ноён Борис Жонсоны саналыг парламентын гишүүд дэмжээгүй байна. Мягмар гарагт Парламентын гишүүд Их Британийг Европын Холбооноос гэрээгүйгээр гаргахыг хориглох хуулийн төслийг олонхийн саналаар дэмжсэн юм.

Хөдөлмөрийн намын дарга ноён Жереми Корбин Ерөнхий сайдыг Англи улсыг Европын холбооноос гэрээгүйгээр гаргахыг хичээж байна хэмээн буруутгажээ. Мөн тэрбээр манай намын гишүүд уг хуулийн төсөл батлагдсан тохиолдолд л ээлжит бус сонгууль явуулахыг дэмжинэ гэж мэдэгдсэн байна.

Шинжээчид, Их Британийг Европын холбооноос хэлэлцээргүй гарах магадлал 80%-тай байгаа хэмээн үзэж байгаа ч "Brexit"-ийн хугацааг 10-р сарын 31-ний өдрөөс хойшлуулах боломжтой юм.

Япон: Ирэх 10-р сард АНУ болон БНХАУ-ын эрх баригчид уулзалт хийх гэж буй мэдэгдэл болон Хонг Конгын үймээн самуун намжиж буйтай холбоотойгоор Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа.

Гэхдээ худалдааны найдвартай түншүүдийн жагсаалтаасаа Японыг хасах шийдвэр энэ сарын сүүлээр хэрэгжиж эхэлнэ гэж БНСУ-ын Худалдааны яамнаас мэдээлжээ.

Өнгөрсөн сард Японы худалдааны найдвартай түншүүдийн жагсаалтаас БНСУ-ыг хассантай холбогдуулан Сөүлийн засаг захиргаа дээрх шийдвэрийг гаргасан байна.

Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний яамны мэдээлснээр, худалдааны түншүүдийн жагсаалтыг өөрчлөх талаар Мягмар гараг хүртэл нийтийн сонсгол явуулах бөгөөд уг шийдвэр энэ сарын сүүлээр хэрэгжиж эхлэх ажээ.

Япон өнгөрсөн 7-р сард БНСУ-ын чухал ач холбогдол бүхий материалуудад экспортын хязгаарлалт тавих шийдвэр гаргаснаас үүдэн хоёр талын маргаан даамжирсан байна.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт АНУ-ын гаалийн татвараас үүдэн удааширсан ч, БНХАУ-ын Төв банкнаас эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээ авч эхэлнэ хэмээн мэдэгдсэн нь хөрөнгийн зах зээлийн индексүүдэд эерэгээр нөлөөлжээ.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,629.00	-0.19% ▼
Dow Jones	АНУ	26,797.46	1.49% ▲
S&P 500	АНУ	2,978.71	1.79% ▲
Nasdaq	АНУ	8,103.07	1.76% ▲
S&P/TSX	Канад	16,535.33	0.57% ▲
FTSE 100	Их Британи	7,282.34	1.04% ▲
S&P/ASX 200	Австрали	6,647.30	0.65% ▲
Nikkei 225	Япон	21,199.57	2.39% ▲
Hang Seng	Хонг Конг	26,690.76	3.76% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	112.64
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	101.87
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	100.84
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.86
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.11
DBM' 2023	USD	7.250%	103.20
TDBM' 2020	USD	9.375%	102.86
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	99.33

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.049	-0.04 ▼
Libor 3M	2.134	0.00 ▼
Libor 6M	2.034	0.00 ▼
Libor 1YR	1.949	-0.02 ▼
US 2YR Bond	1.536	0.03 ▲
US 3YR Bond	1.473	0.05 ▲
US 5YR Bond	1.431	0.04 ▲
US 10YR Bond	1.562	0.07 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.09.07	Өөрчлөлт
USD	2,671.58	-0.02% ▼
CNY	375.45	0.36% ▲
EUR	2,946.49	-0.10% ▼
RUB	40.61	1.05% ▲
KRW	2.24	1.36% ▲
JPY	24.99	-0.44% ▼
CAD	2,028.15	0.98% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,506.82	-0.89% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	18.18	-1.08% ▼
Зэс	USD/lb.	263.40	3.23% ▲
Нүүрс	USD/MT	69.60	5.69% ▲
WTI газрын тос	USD/bbl.	56.52	2.58% ▲
Brent газрын тос	USD/bbl.	61.54	1.84% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. VII	7.70%
Бодлогын хүү	2019. VII	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. VII	10.99%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. VII	11.44%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. VII	4.98%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. VII	16.99%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. VII	10.75%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 57 компанийн 451.3 сая төгрөгийн 2,099,403 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Ард санхүүгийн нэгдэл” /AARD/ компанийн хувьцаа 15.84%-аар буюу хамгийн ихээр өсөж 1,499.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Монгол секюритиес” /MCS/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 340.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 2,860 ширхэг үнэт цаас 29.3 сая төгрөгөөр арилжаалагджээ.

9-р сарын 7-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,488.6 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,629.00 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.19%-аар буурсан байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	744.0
Зах зээлийн үнэлгээ	2,488,601.5

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,629.00	-0.19% ▼
MSE I индекс	9,018.73	-0.28% ▼
MSE II индекс	7,794.90	0.15% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Инвескор ББСБ	63,071	114,365,199
Лэндмн ББСБ	1,409,699	75,422,382
Ард санхүүгийн нэгдэл	43,381	636,630,270
Таван толгой	8,092	54,798,475
АПУ	68,946	35,022,331

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Ард санхүүгийн нэгдэл	1,499.00	15.84% ▲
Даваанбулаг	196.65	15.00% ▲
Могойн гол	9,910.00	14.97% ▲
Монголын цахилгаан холбоо	454.55	13.64% ▲
Жуулчин дютти фрий	110,000.00	10.00% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол секюритиес	340.00	-15.00% ▼
Монгол базальт	300.62	-12.61% ▼
Сор	860.01	-11.97% ▼
Монгол шилтгээн	311.00	-11.14% ▼
Нако түлш	55.00	-8.33% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Новел Инвестмент	454,732,918
Голомт Капитал	222,822,652
Ти Ди Би Капитал	146,294,337
Ард Секюритиз	129,251,526
Мирэ Эссет Секьюритис Монгол	115,900,300

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	508.83	541,487
Таван толгой	6,700.00	352,856
МИК Холдинг	13,700.00	283,718
Говь	279.55	218,080
Инвескор ББСБ	1,920.00	137,718

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-22/05/20-A0248-15.87	1,430	143,000,000	100,000	100,000	156	15.870%
2	ZGEB-BD-22/05/20-A0248-15.87	1,430	149,721,000	104,700	104,700	156	15.870%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.12-с

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Түмэн шувуут” ХК олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайлан ирүүлээ

Монголын хөрөнгийн биржид 2019 онд шинээр үнэт цаасаа бүртгүүлж, олон нийтээс 10 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн “Түмэн шувуут” ХК нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг 2019 оны 8-р сарын 22-ны өдрийн байдлаар дараах байдлаар зарцуулсан тухай тайлан ирүүлсэн байна. Үүнд:

- Өндөглөгч тахианы аж ахуйг өргөтгөх: 1.8 тэрбум төгрөг;
- Шинээр 200,000 шувууны аж ахуй байгуулах: 842 сая төгрөг;
- Сангасны бордооны үйлдвэр байгуулах: 1.1 тэрбум төгрөг;
- Усалгаатай тариаланг өргөжүүлэх: 889.2 сая төгрөг.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Таванбогд трейд” компани “Говь” ХК-ын нийт хувьцааны 28.59%-ийг биржийн бус хэлцэлээр шилжүүлэн авч, компанийн 50.23%-ыг эзэмших болов

Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны I ангилалд бүртгэлтэй “Говь” /MSE:GOV/ компанийн хувь эзэмшилд өөрчлөлт гарлаа. Тус компани нийт 3 том хувьцаа эзэмшигчтэй бөгөөд тэдгээр нь нийтдээ Говь ХК-ийн нийт хувьцааны 84.23%-ийг эзэмшиж байжээ.

Хамгийн том хувьцаа эзэмшигч нь “Хайд Интер” ХХК ба Говь ХК-ын 34%-ийг эзэмшидэг ажээ. Харин 2 дахь том хувьцаа эзэмшигч болох “Эф Си Ай” ХХК нь өөрийн эзэмшлээ “Таванбогд трейд” ХХК-д шилжүүлээ. Энэхүү шилжүүлэх үйл ажиллагаа хөрөнгийн биржийн арилжаагаар явагдаагүй “биржийн бус” хэлцэлээр хийгджээ.

2019 оны 8-р сарын 30-ны байдлаар Говь /MSE:GOV/ компани 17,245 жижиг хувьцаа эзэмшигчтэй байгаа ба жижиг хувьцаа эзэмшигчид нийт хувьцааны 15.77%-ийг эзэмшиж байгаа юм.

Эх сурвалж: MarketInfo.mn

Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмыг яаралтай батламжлуулах хүсэлтийг СЗХ-нд хүргүүлээ

Монголын хөрөнгийн зах зээл сүүлийн жилүүдэд идэвхжиж, үнэт цаас гаргагчдын тоо нэмэгдэж байгааг харгалзан зах зээлд урт хугацааны мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох зорилгоор МХБ нь “Хамтын хаалттай хөрөнгө оруулалттай сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам”-ын төслийг боловсруулж, СЗХ, зах зээлийн оролцогчид болон олон нийтийн саналуудыг тусгаж, 2019 оны 7-р сарын 9-ний өдөр СЗХ-нд батламжлуулахаар хүргүүлсэн билээ.

Тус журмыг олон улсын стандарт болон дотоодын зах зээлийн хууль, дүрэм журмуудад нийцүүлэн боловсруулж, зах зээлийн оролцогчдын саналыг тусгаж олонтаа хэлэлцүүлсний үндсэнд СЗХ-нд хүргүүлсэн хэдий ч журам батламжлагдахгүй 2 сар гаруй хугацаа өнгөрөөд байгаа тул тус журмыг хугацаа алдалгүй батламжлуулах хүсэлтийг СЗХ-нд хүргүүлээ.

Энэхүү журам батламжлагдсанаар олон улсын биржүүдэд түгээмэл арилжаалагддаг бүтээгдэхүүн манай зах зээлд цоо шинээр нэвтэрч, хөрөнгө оруулагчдад эрсдэлээ тараан байршуулж, багц хувьцаанд хөрөнгө оруулах боломжийг олгох төдийгүй зах зээлийг цаашид хөгжүүлэхэд нэн тулгамдаж буй хөрөнгө оруулалтын сангууд бий болох түлхүүр болох юм.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Багануур” ХК 15 тэрбум төгрөгийн зээл авна

“Багануур” /MSE:BAN/ компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс 15 тэрбум төгрөгийн зээлийг арилжааны банкнаас авах шийдвэр гаргасан байна.

Уг зээлийг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулах, өвөлжилтийн бэлтгэлийг хангах зорилгоор авч байгаа бөгөөд энэ асуудлаар Гүйцэтгэх захиралд холбогдох үүргийг өгсөн ажээ. Зээлийг 10 сарын хугацаатай авах юм.

Компанийн хувьд 34.6 тэрбум төгрөгийн урт хугацаат зээл, 38.6 тэрбум төгрөгийн богино хугацаат зээлийн үлдэгдэлтэй байгаа талаар 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайландаа тусгасан байна.

Эх сурвалж: MarketInfo.mn



Хөгжлийн банк охин компаниараа дамжуулан ОХУ-ын шууд хөрөнгө оруулалтын сантай хамтран ажиллана

ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин манай улсад дөрөв дэх удаагаа албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын үеэр хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх 10 баримт бичигт гарын үсэг зурсан юм. Тэдгээрийн нэг нь Монгол Улсын Хөгжлийн банкны охин компани болох “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК болон ОХУ-ын Шууд хөрөнгө оруулалтын сан хооронд хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулсан явдал байлаа. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд талууд рубль-төгрөгийн хамтарсан хөрөнгө оруулалтын санг байгуулж томоохон төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлснээр хоёр улсын эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжих чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

ОХУ-ын Шууд хөрөнгө оруулалтын сан нь 2011 онд ОХУ-ын Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдын санаачилгаар байгуулагдсан бөгөөд 40 орчим тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалтыг ОХУ-ын эдийн засагт татан төвлөрүүлж, нийт 1.5 их наяд рублийн хөрөнгө оруулалтын багцыг удирдаж буй томоохон хөрөнгө оруулалтын сан юм.

“Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК нь МУХБ-ны охин компани хэлбэрээр 2017 онд байгуулагдсан бөгөөд “Хөрөнгө оруулалтын сан” байгуулах замаар мэргэжлийн хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааг Монгол Улсад нэвтрүүлэх юм. Тус компани эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үр ашиг бүхий томоохон төслийг санхүүжүүлэх зорилгоор “Үндэсний стратегийн хөрөнгө оруулалтын сан”-г 2018 онд үүсгэн байгуулж үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байна.

Мөн “Ди Би Эм ассет менежмент ҮЦК” ХХК олон улсын зах зээлээс хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх зорилгынхоо хүрээнд Азийн хөгжлийн банкнаас 75.9 сая ам.долларын эх үүсвэрийн амлалтыг аваад байгаа юм.

Эх сурвалж: Montsame.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Алт худалдан авалт 21 хувиар буурчээ

Монголбанк 2019 оны эхний 8 сард 9.6 тонн үнэт металл худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үед 12.2 тонн үнэт металл худалдан авснаас 2.5 тонноор бага буюу 21 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Монголбанк өнгөрсөн 8-р сард 2.1 тонн үнэт металл худалдан авснаас Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 181.3 кг үнэт металл, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 147.5 кг үнэт металлыг тус тус худалдаж авчээ. Энэ нь өмнөх оны мөн үед 2.8 тонн үнэт металл худалдан авч байснаас 745.7 кг-аар мөн буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны 8-р сард нэг грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 128,129.8 төгрөг байв.

Эх сурвалж: Montsame.mn

Бүс нутгийн эрчим хүчний хамтын ажиллагааг дэмжих санамж бичигт гарын үсэг зурлаа

ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путиний Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал П.Ганхүү, ОХУ-ын “Россети” ХК-ийн Ерөнхий захирал Павел Ливинский нар хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа.

Хамтын ажиллагааны гол чиглэл нь бүс нутгийн эрчим хүчний хамтын ажиллагаа, худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэж, Засгийн газрын бодлого, удирдамжийг хэрэгжүүлэн ажиллах юм.

Зүүн хойд Азийн орнуудыг хамарсан цахилгаан эрчим хүчний нэгдсэн систем бий болгох санаачилга 2010 оноос эхлэн яригдсан. Монгол Улс энэ санаачилгыг анх гаргасны хувьд, бүс нутагт хэрэгжүүлэхийн төлөөх хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож ирсэн юм. Тухайлбал, 2018 онд ОХУ-ын Владивосток хотод болсон Дорнын эдийн засгийн 4 дүгээр чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга оролцоходоо уг санаачилгын хүрээнд бодит төсөл хэрэгжүүлэх санал гаргаж, үүнийг бүс нутгийн удирдагч нар дэмжиж буйгаа илэрхийлсэн.

Мөн өнгөрсөн хоёр жилийн хугацаанд Азийн хөгжлийн банкны төслийн шугамаар Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн систем бий болгох судалгааг хийж дууссан бөгөөд энэ дагуу төслийн хөрөнгө оруулалт, хил дамнасан эрчим хүчний худалдаа хийх чиглэлд бодит алхам хийх үүднээс “Эрдэнэс Монгол” ХХК бүс нутгийн үндэсний томоохон компаниудтай хамтран ажиллах бодлого баримталж байна.

Эрдэнэс Монгол” ХХК-ийн хувьд, цаашид БНХАУ, БНСУ болон Япон улсын компаниудтай энэ чиглэлээр хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Таван толгой түлш: Хэрэгцээнд шаардлагатай сайжруулсан хатуу түлшний 50 хувийг үйлдвэрлээд байна

Энэ онд түүхий нүүрсийг орлуулах сайжруулсан хатуу түлшний хэрэглээний 50 хувийг үйлдвэрлэсэн байгаа талаар “Таван толгой түлш” компанийн Гүйцэтгэх захирал М.Ганбаатар “Coal Mongolia 2019” чуулганы үеэр хэллээ.

Энэ төрлийн түлшийг хэрэглэснээр 2019-2020 онд Улаанбаатар хотын агаарын бохирдлын төвшин 40-50 хувь буурна гэж тооцоолж байгаа юм байна. Монгол Улсын Засгийн газар өнгөрсөн 5-р сараас Улаанбаатарт түүхий нүүрс хэрэглэхийг хориглосон юм.

“Айл өрхүүд нүүрсийг орлуулах сайжруулсан хатуу түлш хэрэглэнэ. Үйлдвэрлэл нь төлөвлөгөөний дагуу явж байгаа, мөн чанарын хяналтыг тогтмол хийж байгаа” гэж Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газрын хэлтсийн дарга Х.Галымбек онцоллоо.

Эх сурвалж: BloombergTv.mn

Монголоос нүүрс шилжүүлэн тээвэрлэх терминал “Зарубино” боомтод байгуулах төсөл эхлүүлснийг зарлав

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Валивостокт болж буй Дорнын эдийн засгийн чуулга уулзалтад оролцсон билээ. Уулзалтын үеэр Монголоос нүүрс шилжүүлэн тээвэрлэх терминалыг “Зарубино” боомтод байгуулах төслийг эхлүүлснийг зарлалаа.

Энэхүү төслийн албан ёсны нэр нь “ОХУ-ын Приморийн хязгаарын Хасан дүүргийн Триоцын буланд нүүрс шилжүүлэн ачих дагнасан терминал барих төсөл” юм байна. Терминалыг “Эрдэнэс Тавантолгой”, ОХУ-ын “Феско” компани хамтран эзэмшинэ. Төслийг эхлүүлснээс тээвэр эхлэх хүртэл гурван жил шаардана гэж төлөвлөж байгаа аж. 2022 оноос 6 сая тонн нүүрс тээвэрлэх бол 2024 онд тээвэрлэлтийн хэмжээг 10 сая тонн хүргэхээр төлөвлөсөн байна.

“Бид Алс Дорнодын “Зарубино” боомтыг эзэмшдэг ОХУ-ын “Феско” компанитай хамтран ажиллахаар тохиролцож, шинээр терминал барих урьдчилсан ТЭЗҮ хийж дуусгаад байна” гэж Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ-ын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр мэдэгдээд байсан юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.